

# ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

7 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/58/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Эрдэнэт хот  
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах  
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn  
Аудитын менежер: Б.Эрдэнэ  
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn  
Аудитор: Б.Азжаргал  
Утас: 70350757 Цахим хаяг: azjargalb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Санал дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.1 Залруулсан алдаа .....	16
4.4 Зөвлөмж .....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



### ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826

Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.08.25 № 61

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМГИЙН 7 ДУГААР  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Ц.ОДГЭРЭЛ ТАНАА

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн 7 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн 7 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc\alban bichig\ 2022-A4.doc

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	110,519,438.11	121,190,137.04
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	931,079.91	291,079.91
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	931,079.91	291,079.91
3121	Төгрөг	931,079.91	291,079.91
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	931,079.91	291,079.91
33	АВЛАГА	1,618,979.90	1,618,979.90
335	Бусад авлага	1,618,979.90	1,618,979.90
3351	Байгууллагаас авах авлага	1,618,979.90	1,618,979.90
35	БАРАА МАТЕРИАЛ	107,969,378.30	119,280,077.23
351	Түүхий эд материал	29,279,993.40	41,413,268.60
35110	Тусгай зориулалттай материал	28,474,303.40	40,707,768.60
35130	Эм боох материал	805,690.00	705,500.00
354	Хангамжийн материал	78,689,384.90	77,866,808.63
35410	Бичиг хэргийн материал	3,509,127.10	3,084,114.00
35420	Аж ахуйн материал	6,954,753.00	4,966,518.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,071,000.00	1,100,000.00
35440	Түлш, шатах тослох материал	6,838,935.12	3,487,146.53
35470	Бусад хангамжийн материал	59,315,569.68	65,229,030.10
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,256,254,840.57	3,230,607,337.98
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,256,254,840.57	3,230,607,337.98
392	Биет хөрөнгө	2,858,552,340.50	2,833,034,837.87
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,834,505,507.88	2,834,505,507.88
39202	Хуримтлагдсан элэгдэл	(93,403,583.16)	(129,387,896.52)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	40,000,000.00	40,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(40,000,000.00)	(40,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	220,179,624.39	220,906,667.31
39206	Хуримтлагдсан элэгдэл	(183,918,225.62)	(170,138,885.54)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	141,736,543.87	145,445,115.93
39208	Хуримтлагдсан элэгдэл	(96,185,068.91)	(98,334,776.08)
39209	Зам, гүүрийн байгууламж	46,344,277.33	46,344,277.33
39210	Хуримтлагдсан элэгдэл	(10,706,735.28)	(16,305,172.44)
393	Биет бус хөрөнгө	397,702,500.07	397,572,500.11
39301	Програм хангамж	2,662,784.00	2,662,784.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,240,283.93)	(2,370,283.89)
39303	Бусад биет бус хөрөнгө	397,280,000.00	397,280,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,366,774,278.68	3,351,797,475.02

**7 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,366,774,278.68	3,351,797,475.02
51	Засгийн газрын хувь оролцоо	3,366,774,278.68	3,351,797,475.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,493,834,578.34	1,493,834,578.34
51101	Өмч: - төрийн	1,493,834,578.34	1,493,834,578.34
512	Хуримтлагдсан үр дүн	(484,026,304.29)	(499,003,107.95)
51210	Өмнөх үеийн үр дүн	(484,026,304.29)	(484,026,304.29)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(14,976,803.66)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,356,966,004.63	2,356,966,004.63
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,366,774,278.68</u>	<u>3,351,797,475.02</u>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,066,123,273.37	1,108,045,214.39
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,247,773.37	48,334,608.94
120	Нийтлэг татварын бус орлого	14,247,773.37	48,334,608.94
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,247,773.37	48,334,608.94
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	290,000.00	386,456.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	13,957,773.37	47,948,152.94
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,051,875,500.00	1,059,710,605.45
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,004,765,100.00	1,001,558,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,004,765,100.00	1,001,558,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	11,640,605.45
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	11,570,605.45
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	70,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	47,110,400.00	46,511,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	47,110,400.00	46,511,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,102,511,401.97	1,123,022,018.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,102,511,401.97	1,123,022,018.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,067,669,272.30	1,074,576,474.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	841,850,610.43	824,780,734.55
210101	Үндсэн цалин	536,918,375.31	535,650,562.94
210102	Нэмэгдэл	241,129,024.69	224,645,471.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,587,710.43	2,664,300.00

7 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210104	Урамшуулал	58,215,500.00	61,820,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,979,512.63	108,495,529.41
210201	Тэтгэврийн даатгал	72,894,641.52	76,456,050.33
210202	Тэтгэмжийн даатгал	8,601,883.13	8,578,449.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,780,706.51	6,634,225.19
210204	Ажилгүйдлийн даатгал	1,609,298.31	1,529,709.57
210205	Эрүүл мэндийн даатгал	16,092,983.16	15,297,095.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,101,627.77	39,230,948.94
210301	Гэрэл, цахилгаан	4,533,470.96	6,095,943.10
210302	Түлш, халаалт	26,343,207.01	27,887,343.84
210303	Цэвэр, бохир ус	6,224,949.80	5,247,662.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,575,563.65	13,264,282.31
210401	Бичиг хэрэг	381,055.90	1,363,948.10
210402	Тээвэр, шатахуун	1,348,050.88	4,351,788.59
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	908,089.50	703,420.62
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,550,330.00	2,073,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,308,850.00	3,221,510.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	225,450.00	1,549,815.00
210408	Бараа материал актальсны зардал	4,853,737.37	-
2105	Нормативт зардал	5,193,760.00	9,652,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	84,160.00	601,800.00
210502	Хоол, хүнс	5,109,600.00	8,712,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	339,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	4,135,750.00
210604	Урсгал засвар	-	4,135,750.00
2107	Томилолт, зочны зардал	320,000.00	56,000.00
210702	Дотоод албан томилолт	320,000.00	56,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,152,500.00	7,658,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	144,500.00	6,650,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,495,697.82	67,302,429.74
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,326,971.00	7,444,799.83
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	61,168,726.82	59,857,629.91
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,842,129.67	48,445,543.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,546,100.00	40,821,630.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,853,600.00	38,741,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,692,500.00	2,079,930.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7,664,422.23	3,867,451.06
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,664,422.23	3,867,451.06

**7 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,631,607.44	3,756,462.04
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,631,607.44	3,756,462.04
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(36,388,128.60)	(14,976,803.66)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(36,388,128.60)	(14,976,803.66)

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,493,834,578.34	2,356,966,004.63	(484,026,304.29)	3,366,774,278.68
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,493,834,578.34	2,356,966,004.63	(484,026,304.29)	3,366,774,278.68
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(14,976,803.66)	(14,976,803.66)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,493,834,578.34	2,356,966,004.63	(499,003,107.95)	3,351,797,475.02

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,070,914,714.00	1,078,171,069.45
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	290,000.00	386,456.00
120	Нийтлэг татварын бус орлого	290,000.00	386,456.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	290,000.00	386,456.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	290,000.00	386,456.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,070,624,714.00	1,077,784,613.45
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,004,765,100.00	1,001,558,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,004,765,100.00	1,001,558,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	11,640,605.45
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	11,570,605.45

7 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	70,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	47,110,400.00	46,511,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	47,110,400.00	46,511,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	18,749,214.00	18,074,008.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	18,749,214.00	18,074,008.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,072,464,714.00	1,078,811,069.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,072,464,714.00	1,078,811,069.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,018,873,370.33	1,011,321,918.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	841,850,610.43	824,780,734.55
210101	Үндсэн цалин	536,918,375.31	535,650,562.94
210102	Нэмэгдэл	241,129,024.69	224,645,471.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,587,710.43	2,664,300.00
210104	Урамшуулал	58,215,500.00	61,820,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,979,512.63	108,495,529.41
210201	Тэтгэврийн даатгал	72,894,641.52	76,456,050.33
210202	Тэтгэмжийн даатгал	8,601,883.13	8,578,449.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,780,706.51	6,634,225.19
210204	Ажилгүйдлийн даатгал	1,609,298.31	1,529,709.57
210205	Эрүүл мэндийн даатгал	16,092,983.16	15,297,095.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,101,627.77	39,230,948.94
210301	Гэрэл, цахилгаан	4,533,470.96	6,095,943.10
210302	Түлш, халаалт	26,343,207.01	27,887,343.84
210303	Цэвэр, бохир ус	6,224,949.80	5,247,662.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,865,469.50	9,597,505.45
210401	Бичиг хэрэг	473,400.00	2,323,084.83
210402	Тээвэр, шатахуун	7,500,000.00	1,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	908,089.50	703,420.62
210404	Ном, хэвлэл	428,700.00	526,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,042,480.00	656,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,512,800.00	4,388,600.00
2105	Нормативт зардал	6,302,000.00	9,676,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	313,500.00	778,200.00
210502	Хоол, хүнс	5,109,600.00	7,742,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	878,900.00	1,155,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,344,350.00	5,413,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	2,000,000.00
210604	Урсгал засвар	2,344,350.00	3,413,400.00
2107	Томилолт, зочны зардал	320,000.00	56,000.00
210702	Дотоод албан томилолт	320,000.00	56,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,152,500.00	7,658,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	144,500.00	6,650,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,957,300.00	6,413,800.00

**7 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,957,300.00	6,413,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,591,343.67	67,489,151.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,295,314.00	59,865,238.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	18,749,214.00	18,074,008.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,853,600.00	39,711,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,692,500.00	2,079,930.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7,664,422.23	3,867,451.06
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,664,422.23	3,867,451.06
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,631,607.44	3,756,462.04
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,631,607.44	3,756,462.04
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(1,550,000.00)	(640,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(1,550,000.00)	(640,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		931,079.91
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	931,079.91	291,079.91

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,050,797,000.00	1,040,902,542.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,050,797,000.00	1,040,902,542.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,009,645,500.00	999,751,312.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	829,304,900.00	824,780,734.55
210101	Үндсэн цалин	537,937,900.00	535,650,562.94
210102	Нэмэгдэл	226,882,300.00	224,645,471.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,664,300.00	2,664,300.00
210104	Урамшуулал	61,820,400.00	61,820,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,304,200.00	108,495,529.41
210201	Тэтгэврийн даатгал	76,132,100.00	76,456,050.33
210202	Тэтгэмжийн даатгал	8,293,000.00	8,578,449.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,634,400.00	6,634,225.19
210204	Ажилгүйдлийн даатгал	1,658,600.00	1,529,709.57
210205	Эрүүл мэндийн даатгал	16,586,100.00	15,297,095.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,098,400.00	39,230,948.94
210301	Гэрэл, цахилгаан	5,736,500.00	6,095,943.10
210302	Түлш, халаалт	30,452,400.00	27,887,343.84

7 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	6,909,500.00	5,247,662.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,826,900.00	7,826,900.00
210401	Бичиг хэрэг	658,000.00	952,479.38
210402	Тээвэр, шатахуун	1,000,000.00	1,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	990,700.00	703,420.62
210404	Ном, хэвлэл	526,400.00	526,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	263,200.00	256,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,388,600.00	4,388,600.00
2105	Нормативт зардал	9,676,000.00	9,676,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	778,200.00	778,200.00
210502	Хоол, хүнс	7,742,400.00	7,742,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,155,400.00	1,155,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,413,400.00	3,413,400.00
210604	Урсгал засвар	3,413,400.00	3,413,400.00
2107	Томилолт, зочны зардал	546,800.00	56,000.00
210702	Дотоод албан томилолт	546,800.00	56,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,211,100.00	1,008,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,211,100.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,263,800.00	5,263,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,263,800.00	5,263,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,151,500.00	41,151,230.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,151,500.00	41,151,230.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	39,711,300.00	39,711,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,440,200.00	1,439,930.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,050,797,000.00</b>	<b>1,040,902,542.90</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,001,558,200.00</b>	<b>997,871,737.96</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,001,558,200.00	997,871,737.96
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>46,511,800.00</b>	<b>42,644,348.94</b>
132001	Орон нутгийн төсвөөс	46,511,800.00	42,644,348.94
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>2,727,000.00</b>	<b>386,456.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,727,000.00	386,456.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		931,079.91
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		291,079.91
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>42.00</b>	<b>42.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	29.00	29.00
620003	Үйлчлэх ажилтан	12.00	12.00
63	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>

7 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	1.00	1.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	1.00	1.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

### НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,570,605.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,570,605.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,570,605.45
2104	Хангамж, бараа материалын зардал	1,770,605.45
210401	Бичиг хэрэг	1,370,605.45
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	400,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,650,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,650,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,150,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,150,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,640,605.45
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,640,605.45
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,640,605.45

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу 7 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Азжаргал гүйцэтгэж хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

7 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

7 дугаар сургууль нь ажлын байран дахь багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжин, хосолмол сургалт, үйл ажиллагааны чанар үр дүнг дээшлүүлэх, эрүүл чийрэг зөв боловсон сурах арга барил эзэмшсэн хүүхэд төлөвшүүлэх зорилго бүхий БШУЯамны харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын хууль тогтоомж, Нийгмийн даатгалын тухай хууль, ТБОНӨХБАҮХАТХууль тогтоомжид өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

7 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн, төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв болох 1,050,908.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 10,509.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 7,356.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад өөрчлөөгүй болно.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

7 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,976.8 мянган төгрөгөөр буюу 0.45 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	931.0	291.0	(640.0)
Бараа материал	107,969.3	119,280.0	11,310.7
Үндсэн хөрөнгө	3,256,254.8	3,230,607.3	(25,647.5)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,365,155.1</b>	<b>3,350,178.3</b>	<b>(14,976.8)</b>
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,366,774.3	3,351,797.5	(14,976.8)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,366,774.3</b>	<b>3,351,797.5</b>	<b>(14,976.8)</b>

Бараа материалын данс 119,280.0 мянган төгрөг болж 11,310.7 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалттай материал, бусад хангамж буюу ном сурах бичгийн дансны үлдэгдэлээс /БШУЯамнаас ирсэн сурах бичиг бараа материалын дансанд орлогод авсан/ шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,230,607.3 мянган төгрөг болж 25,647.5 мянган төгрөгөөр буурсан тайлант үеийн элэгдлээс шалтгаалсан.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,351,797.5 мянган төгрөг болж 14,976.8 мянган төгрөгөөр буурсан шалтгаан нь үндсэн хөрөнгө акталсантай холбоотойгоор тайлант үеийн үр дүн буурсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 1,108,045.2 мянган төгрөгөөр буюу 9.6 хувиар, нийт зардал өмнөх оноос 1,123,022.0 мянган төгрөгөөр буюу 11.1 хувиар тус тус өссөн байна.

Орхон аймгийн 7 дугаар сургууль нь 2021 оны батлагдсан төсвийн төлөвлөгөөний дагуу туслах үйл ажиллагааны орлогод 2,727.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 386.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Ковидтой холбоотойгоор заал болон гал тогооны түрээсийн орлого 2,340.5 мянган төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

7 дугаар сургууль нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,059,468.6 мянган төгрөгөөр төлөвлөн хүргүүлсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1,001,558.2 мянган төгрөгийг улсын төсвөөс урсгал санхүүжилт, 46,511.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн санхүүжилт, туслах үйл ажиллагааны орлогоос 2,727.0 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөж, улсын төсвөөс 997,871.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 42,644.3 мянган төгрөг, туслах үйл ажиллагаас 386.5 мянган

төгрөгийн санхүүжилт авч, урсгал зардалд нийт 1,040,902.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,040,902.5 мянган төгрөг буюу цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 824,780.7 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 108,495.5 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлалд 39,230.9 мянган төгрөг, хангамжийн материалын зардалд 7,826.9 мянган төгрөг, норматив зардал 9,676.0 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 3,413.4 мянган төгрөг, томилт зочны зардал 56.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 1,008.0 мянган төгрөг, бусад бараа үйлчилгээний зардалд 5,263.8 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгийн зардалд 41,151.2 мянган төгрөг зарцуулсан ба хэмнэгдсэн зардал болох нийт 7,553.9 мянган төгрөгөөс орон нутгийн төсөвт 3,867.4 мянган төгрөгийг, улсын төсөвт 3,686.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд БСУГазраас 11,570.6 мянган төгрөг, цахим тендерийн олроого 70.0 мянган төгрөг нийт 11,640.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж, бараа материалын зардалд 1,770.6 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 2,000.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардалд 6,650.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 1,150.0 мянган төгрөг зарцуулж, улсын төсөвт 70.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай. Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

7 дугаар сургууль нь 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 138 мэдээллийг бүрэн мэдээлж, 11 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин зарлагын гүйлгээ хийхдээ цахим төлбөрийн e-баримтгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоол, 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 17,283.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнээс 1,311.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж, 15,972.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 албан шаардлага хүргүүлсэн нь бүрэн хэрэгжсэн байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Зөвлөмж	1	1,311.2	1	1,311.2	0	0	0
Албан шаардлага	2	15,972.0	2	15,972.0			
Нийт дүн	3	17,283.2	3	17,283.2	0	0	0

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

#### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 1,800.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 140.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 960.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж, 700.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага өгсөн.

##### **4.1 Залруулсан алдаа**

Зардлын зүйл ангийг буруу сонгосоноор санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд 140.0 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлсэнийг залруулав.

##### **4.2 Төлбөрийн акт Байхгүй.**

##### **4.3 Албан шаардлага**

Засгийн газраас баталсан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэлгүй 700.2 мянган төгрөгийн нормын хувцас бэлтгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолтой тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

##### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал**

##### **1.1. Илрүүлэлт:**

Зарлагын гүйлгээ хийхдээ анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй 825.8 мянган төгрөгийн дутуу баримтаар гүйлгээ хийсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

##### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Батлагдсан төсвийн зарцуулалтад үр дүнтэй хяналт хэрэгжүүлэх, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй баримтаар гүйлгээ хийхгүй байх.

##### **1.3. Илрүүлэлт:**

Бага ангийн багшид 134.9 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгоогүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.4-д "төрийн жинхэнэ албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоход Засгийн газраас баталсан төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журамд заасан нөхцөл, шалгуурыг баримтална" гэсэн заалттай нийцэхгүй байна.

##### **1.4. Өгсөн зөвлөмж:**

7 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлэх, хууль тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаа явуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	7 дугаар сургууль	4	1,800.9	1	140.0	0	0	1	700.2	2	960.7